

явцад миний шавь Насан-Өлзий, Мөнхцэцэг, Өлзийт нар их тусламж дэмжлэг үзүүлсэнд баярлан талархсанаа илэрхийлье. Энэхүү өгүүлэлд дурдсан бүхнийг зөв оновчтой гэж хэлж чадахгүй, миний эрдэм бага, чадвар дорой, үзэж сонссон зүйл цөөхөн, нөхцөл бололцоо тийм сайн биш зэрэг шалтгаанаас болж өдий төдий алдаа байж мэднэ. Уншигч эрдэмтэд, мэргэд гэгээн ухаандаа толидож заан сургахыг бие мэхийн хүлиемү. Бид агуу их үндэстэн Хүн-Түргүүд-Монголын хойчис үр удам бологсдын хувьд бусад хүмүүсийн элдэв яриаг хайхрахгүй олноороо, хэдэн үе дамжин шантаршгүй оролдож судалж л байвал өөрийн язгуур дээдсээ зөв таних болно хэмээн лавтайяа итгэж байна.

Кирил үсгэнд буулгасан З.Хасбагана

**Ялтын бага хурал ба БНМАУ-ын
статус-квогийн асуудал**

Ц.Батбаяр

Дэлхийн 2-р дайны төгсгөлийн шатанд Алс Дорнод дахь Японы эсрэг дайны ажиллагаанд ЗХУ-ыг оролцуулах асуудалтай холбогдон БНМАУ-ын дайны дараах олон улсын статусын асуудал яригдаж эхэлжээ. Анх энэ асуудлыг 1943 оны 11 дүгээр сард Кайрт болсон их гүрнүүдийн удирдагчдын уулзалт дээр Чан Кайши сөхөж тавьсан гэж үздэг. Тэнд Чан АНУ-ын ерөнхийлөгч Рузвельтэд хандан “БНМАУ-ыг Хятадын бүрэлдэхүүнд оруулах” хүсэлтийг тавьсан боловч Рузвельт энэ асуудлыг ЗХУ-тай ярилцаж шийдэхгүй бол болохгүй гэж шалтаглан хойш тавьсан байна.¹ Америкийн түүхч Жон Гарверын бичсэнээр Кайрт болсон хурлын үеэр Чан Кайши болон Рузвельт нар 11 дүгээр сарын 25 ны өдөр дайны дараа Манжуурыг Хятадад буцааж өгөх тухай үндсэндээ тохиролцсон боловч Гадаад Монголын талаар тохиролцсон зүйл үгүй гэжээ. Харин тэр уулзалтын үеэр Рузвельт Танну Тувагийн тухай Чан Кайши-гаас сонирхон асууж санал бодлыг нь сонсож байжээ.²

БНМАУ-ын асуудлыг 1945 оны хавар болсон Ялтын бага хурлаар үндсэндээ их гүрнүүд хэлэлцэж тогтсон байна. Уг Ялтын бага хуралд бэлтгэх явцад Сталин Москвад суугаа АНУ-ын элчин сайд Гарримантай 1944 оны 10 дугаар сарын 15-нд уулзаж Японы эсрэг дайнд орох ЗХУ-ын болзол хэд хэдийг дэвшүүлэн тавьжээ. Үүний дотор БНМАУ-ын тусгаар

тогнолын асуудлыг багтаан ярьсан байна. Сталин БНМАУ-ын статус-квог хадгална гэдэг нь Гадаад Монголыг бие даасан субъектын хувьд байлгахыг хэлж байгаа юм” гэж Гарриманд шууд мэдэгдэж байжээ.

Ялтын бага хурлын үеэр 1945 оны 2 дугаар сарын 8 нд Сталин Рузвельтээс “Гадаад Монголын статус-квог хадгалах асуудлыг хэрхэн үзэж байна вэ?” гэж тулган асуужээ. Рузвельт үүнд хариулахдаа “Энэ асуудлаар Чан Кайши-тай зөвлөлдөж амжаагүй, гэвч Гадаад Монголын статус-квог хэвээр хадгалах нь зүйтэй гэж бодож байна” хэмээсэн хариулт өгчээ.³

Сталин эдгээр болзлыг тавих болсон шалтгааныг Рузвельтэд тайлбарлахдаа “Хэрвээ эдгээр болзлыг хангуулж чадахгүй бол Молотов бид хоёр Японы эсрэг дайнд ЗХУ оролцох болсон учир шалтгааныг зөвлөлтийн ард түмэнд тайлбарлан таниулж чадахгүйд хүрнэ. Хэрвээ эдгээр болзол хангагдах юм бол ард түмний хувьд улс орныхоо төрийн эрх ашгийн тухай асуудал гэдгийг ойлгуулахад амар бөгөөд Дээд Зөвлөлд ч уг шийдвэрийг тайлбарлахад хялбар болох юм” гэжээ. Ийнхүү холбоотон 3 гүрний төрийн тэргүүн нарын Ялтын бага хурлын 1945 оны 2 дугаар сарын 11 нд гаргасан эцсийн шийдвэрт “Гадаад Монголын БНМАУ-ын статус квог хадгалах” гэсэн зүйлийг ЗХУ-аас Японы эсрэг дайнд оролцох улс төрийн болзлуудын нэгдүгээрт бичиж оруулсан байна. Гадаад Монголын асуудлаар Хятадын засгийн газрын Чан Кайши-гийн зөвшөөрөл хэрэгтэй байсан тул Сталины санал болгосноор АНУ-ын ерөнхийлөгч Рузвельт дээрх асуудлаар Чан Кайши-тай ярьж түүнийг зөвшөөрүүлэх үүргийг өөртөө авсан байна.⁴

Жон Гарверын бичсэнээр холбоотон 3 гүрний тэргүүн нар Ялтын гэрээний бүрэн эхийг чанд нууцалж байжээ. Чунцинд сууж байсан АНУ-ын Элчин сайд Хэрли Ялтын гэрээний бүрэн эхийг 1945 оны 6 дугаар сарын 15 нд Чан Кайши-д албан ёсоор гардуулжээ. Гэвч бүр 2 дугаар сард Москвагаас Хятадын элчин сайд Фу Бинчан уг гэрээний агуулгын тухай мэдээлж байснаас гадна 3 дугаар сарын 13 нд Рузвельт өөрөө Вашингтонд суугаа Хятадын элчин сайд Вэй Даоминд Ялтын гэрээний тухай” мэдээллийг өгч байжээ.⁵

Зөвлөлтийн шинэ элчин сайд Аполлон А. Петров 1945 оны 6 дугаар сарын 1 нд Чунцинд хүрэлцэн ирсэн байна. Чан Кайши Петровыг 6 дугаар сарын 3 нд хүлээн авч Манжуурт

Гоминьданы засгийн газрын бүрэн эрхийг сэргээхэд ЗХУ туслана гэдэгт найдаж байгаага илэрхийлжээ. 6 дугаар сарын 12 нд болсон 2 дахь удаагийн уулзалт дээр Петров хоёр орны хооронд найрамдлын гэрээ байгуулах 5 урьдчилсан нөхцөл гэдгийг дэвшүүлэн тавьсны нэг нь БНМАУ-ын асуудал байв.⁷

1945 оны 6 дугаар сарын сүүлээр Зөвлөлт засгийн газар Дундад Иргэн улсын Үндэсний Гүйцэтгэх Юаны дарга, ГЯЯ ны сайд Сүн Зывэнь, Ван Шизе, Зян Зинго зэрэг өндөр тушаалын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг урьж ЗХУ, ДИУ-ын хооронд холбоо, найрамдлын тухай гэрээ байгуулах болон Крымын бага хурлын шийдвэрт тусгагдсан бусад асуудлаар Москвад Хэлэлцээ хийсэн байна. Хэлэлцээний үндсэн асуудлын нэг нь БНМАУ-ын статус-квогийн асуудал болж хувирчээ. Өөрөөр хэлбэл Ялтын бага хурлын шийдвэрт тусгагдсан БНМАУ-ын статус-кво гэдгийг юу гэж ойлгох вэ гэдэг асуудлаар хоёр тал тун ширүүн маргалдаж, хэлэлцээ байн байн тасалдахад хүрч байв.

Зөвлөлт-Хятадын хэлэлцээ 6 дугаар сарын 30 нд эхэлж эхний үе шат нь 7 дугаар сарын 13 хүртэл явагдаж, түр завсарласны дараа 8 дугаар сарын 7 наас 14 нд 2 дахь шатны хэлэлцээ явагджээ. Хятадын төлөөлөгчдийг Сүн зывэнь даргалж, төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Ван Шизе /хэлэлцээний 2 дахь ээлжинд Хятадын төлөөлөгчдийг тэргүүлэх болсон/, Зян Зинго Чан Кайшингийн хүү/, Москвад суугаа элчин сайд Фу Бинчан нар орж байв. Зөвлөлтийн төлөөлөгчдийг Сталин өөрөө тэргүүлж Молотов, Чунцинд суугаа Элчин сайд Петров нар хэлэлцээнд оролцсон байна.⁷

Сталин, Молотов нар Сун Зывэнийг анх удаа 1945 оны 6 дугаар сарын 30 нд хүлээн авч уулзсан байна. Энэ уулзалтаар Сун Зывэнь Чан Кайши-гийн хувийн илгээлтийг Сталинд гардуулж Чан Кайши түүнд Сталинтай элдэв дипломат зангүй хамгийн илэн далангүй ярьж ирэхийг даалгасан гэж мэдэгджээ. Сталин үүний хариуд өмнө нь Орос улс Японтой холбоо тогтоон Хятадыг хувааж эзэгнэхийг оролдож байсан үе түүхэнд бий. Одоо бид Хятадтай холбоо тогтоон Японыг хазаарлан барихыг хүсч байна. Бидний энэ байр суурь хэд хэдэн бодит шалтгаантай юм. Эдгээр асуудлаар бид хэлэлцэн тохиролцож чадна гэж найдаж байна гэжээ.⁸

1945 оны 7 дугаар сарын 2 нд болсон Сталин-Сун Зывэнь нарын 2 дахь уулзалтын үеэр БНМАУ-ын талаар хоёр тал зарчмын ялгаатай байр суурьтай болох нь тодорхой болсон

байна. Уг хэлэлцээний АНУ-ын Гуверын архивт хадгалагдаж буй англи хэл дээр орчуулсан протоколоос үзвэл Сталин-Сун Зывэнь нарын хэлэлцээ дараах байдлаар эхэлжээ.

Сталин хэлэлцээ эхлэнгүүт Сун Зывэньд нэгэн бичиг баримтыг түлхэн ойртуулж “Үүнтэй танилцсан уу?” гэж асуусан байна. Сун түүнийг Ялтын гэрээ болохыг ойлгож “Бид хүлээж авсан. АНУ-ын тал бидэнд танилцуулсан юм” гэж хариулжээ. Сталин үүнд “Энэ баримт бичиг манай Хэлэлцээний үндэс болох ёстой. Рузвельт гарын үсгээ зурсан юм шүү.” гэсэн байна.

Ялтын гэрээний асуудлаар Чан Кайши Хятадад суугаа ЗХУ-ын элчин сайд Петровтай хоёр ч удаа ярилцсаныг сануулаад Сун Зывэнь уг гэрээний асуудал нэг бүрээр саналаа Хэлэх зөвшөөрлийг Сталинаас хүсчээ. Шууд л эхний асуудал БНМАУ-ын асуудал байлаа. Сун ч “Гадаад Монголын асуудлыг бид одоо хөндөж тавихыг хүсэхгүй байна. Чан Кайши ч тэгж хэлсэн. Ирэх цаг хугацаа шийднэ биз. Үүнийг хойш тавия.” гэсэн саналыг шууд дэвшүүлжээ.

Сталин үүнд “Бид үүнийг зөвшөөрөхгүй” гээд, “Гадаад Монголын газар зүйн байрлалд бүх учир байгаа юм. Хэн нэг нь хүсвэл тэндээс Алс Дорнод дахь Зөвлөлтийн байр суурийг амархан сулруулж чадна. Энэ дайнаас өмнө Япон Чит, Эрхүүд тулж очин цааш давшихыг оролдож байсан ч үе бий. Цааш нь Сталин Гадаад Монгол яагаад тусгаар улс байх ёстойг Сунд илэн далангүй тайлбарласан байна. “Хэрвээ бид Гадаад Монголыг хамгаалах ямар нэг хууль эрхийн үүрэг байгаагүй бол Алс Дорнодоо тэр чигээр нь Японд алдаж гүйцэх байсан. Япон нь Германтай адилхан үг дуугүй бууж өгөх болзлыг хүлээж авлаа ч гэсэн бүрмөсөн устан арилахгүй. Герман, Япон энэ хоёр үндэстэн бол маш хүчтэй. Версалийн гэрээ /1919 онд Германыг буулгаж авсан гэрээг хэлж байна/-ний дараа Германыг дахин босож ирэхгүй гэж бүгд бодож байсан. Гэтэл Герман 15-20 жилийн дараа эргээд босоод ирсэн. Хэдий Японыг өвдөг сөгдүүлсэн боловч эргээд босоод ирэхгүй гэх баталгаа байхгүй. Ийм учраас бид өөрийн Алс Дорнод дахь газар нутгийг хамгаалахын тулд Гадаад Монголд хуулийн эрх олж авах ёстой юм” гэж Сталин учирласан байна.

Мөн Сталин “Гадаад монголчууд Хятадтай ч тэр, ЗХУ-тай ч тэр нэгдэхийг хүсэхгүй. Тэд тусгаар тогтнохыг л хүсэж байгаа. Хятадын хувьд Гадаад Монголыг тусгаар болгох нь илүү

ашигтай. Хэрвээ тэгэхгүй бол Гадаад Монгол бүх монголчуудыг татан нэгтгэх аюултай. Ингэж Дотоод, гадаад Монгол нэгдвэл Хятадад ч, мөн бидэнд ч харшлах болно” гэж Сун Зывэнийг ятгасан байна.

Сталин энэ ярьсан бүх зүйлээ дүгнэн БНМАУ-ыг тусгаар тогтноулах хоёр үндсэн шалтгаан гэдгээ Сунд танилцуулжээ. Нэгд, Японы эсрэг стратегийн байр сууриа бэхжүүлэх. Порт Артур, Дорнод Хятадын төмөр зам, Өмнөд Сахалин, Гадаад Монгол эд бүгд нь Японы эсрэг манай цэрэг-стратегийн байр суурийг бэхжүүлэх зорилготой юм. Түүнээс биш бид ашиг хонжоо бодсон юм биш. Хоёрт, бид 4 жилийн турш дайтаж их цус урсгасан. Герман бидэнд халдсан тул түүнтэй байлдах хэрэгтэйг ард түмэн сайн ойлгож байсан. Харин бид эхлээд нөгөө этгээд рүү дайрах юм бол ард түмэн дайнд уулгалан орох нь юу л бол. Япон одоо биднийг яах нь вэ гээд чимээгүй ширтэж байгаа боловч бид Японыг дайрах болоод байна. Хэрвээ бид Японыг дайрвал ард түмэндээ юу гэж хэлэх вэ? 4 жил байлдаж дуусчихаад дахиад шинэ дайн эхэллээ гэнэ шүү дээ. Япон бидэнд гар хүрээгүй байхад та нар Японд халдлаа гэнэ. Японы эсрэг дайнд оролцох болсноо би юу гэж зөвтгөх вэ?

Сун Зывэнь үүний хариуд энэ асуудлаархи Хятадын засгийн газрын байр суурийг дараах байдлаар тайлбарлажээ. “Бид маш хүнд байдалд байна. Газар нутгийнхаа нэг хэсгийг өгөх болсныг бид ард түмэндээ юу гэж тайлбарлах вэ? Энэ нь Японы эсрэг стратегийн ач холбогдолтой юмаа гэж сая Сталин ярьлаа. Бид энэ асуудлыг одоо сөхөж тавихыг хүсэхгүй байна. Өмнө нь ЗХУ-ын зүгээс Гадаад Монголыг Хятадын салшгүй нэг хэсэг гэдгийг удаа дараа хүлээн зөвшөөрч байсан. Одоо болохоор Гадаад Монголын статус-квог бид хүлээн зөвшөөрөх юм бол Хятадын ямар ч засгийн газар ард түмэндээ тайлбарлаж чадахгүй. Сталин өөрөө Хятад улсыг тогтвортой, нэгдсэн байдалтай байлгахыг хүсэж байгаа. Иймд энэ асуудлыг ярьж хэлэлцээг хүндрүүлэх хэрэггүй гэж бид үзэж байна” гэж хариу учирласан байна.

Ялтын гэрээний бусад асуудлаар хэсэг хугацаанд санал солилцсоны дараа Сталин, Сун нар эргээд л БНМАУ-ын асуудал дээр тулж иржээ. Сун “Хятадын газар нутгийн бүрэн бүтэн байдлын үүднээс Гадаад Монголыг тусгаарлах ямар ч боломжгүй юм. Сталин яагаад энэ асуудал дээр бидэнд туслахгүй байна. Бид хятадын ард түмэнд ойлгуулж чадахгүй”

гэжээ. Үүнд Сталин “Монголчууд Хятадтай цуг байхыг хүсэхгүй байна. Бид ч тухайн үед Польш, мөн Финляндийг тусгаар улс болохыг зөвшөөрсөн. Энэ нь маш хэцүү, тэгэхдээ боломжгүй зүйл биш. Порт Артурын асуудлаар бид та нарт буулт хийсэн. Монголын асуудлаар та нар буулт хийх ёстой.” гэсэн хариулт өгчээ.

Энэ 2 дахь уулзалтаас Сун Зывэнь нарын хятадын төлөөлөгчид Зөвлөлтийн удирдлага, ялангуяа Сталины Монголын асуудлаархи байр суурь тун хатуу болохыг бүрэн ойлгосон тул энэ асуудлаар АНУ-ын дэмжлэгийг олж авахыг чухалчилжээ. Үүний тулд тэд Москвад суугаа АНУ-ын элчин сайд Гарримантай дахин дахин уулзаж “БНМАУ-ын статус квог хадгалах” гэсэн асуудлаар АНУ-ын байр суурийг тодорхой болгож өгөхийг хичээнгүйлэн хүссэн байна. Гарриманы асуулгыг хүлээж аваад тэр үеийн АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Бирнс 7 дугаар сарын 4 нд дараах агуулгатай цахилгааныг Гарриманд илгээжээ. “АНУ-ын засгийн газар нь Монголын статус-квог хэрхэн ойлгох вэ гэх мэтээр Ялтын гэрээний зүйл ангийг нарийн хэлэлцээгүй гэдгийг та мэдэж байгаа” гэжээ. Бирнс мөн АНУ-ын засгийн газар нь Ялтын гэрээний зүйл ангийг албан ёсоор ганцаар дур мэдэн тайлбарлах аргагүй гэдгийг учирлаад түүний хувийн бодлоор бол “хууль эрхийн үүднээс Гадаад Монголыг эзэн мэдэх эрх /суверенитет/ Хятадад байж болох боловч үнэн хэрэгтээ энэ нь хэрэгжих бололцоогүй зүйл юм” гэсэн булзаарсан хариу өгчээ.⁹

Энэ завсар ч Зөвлөлтийн удирдагчид БНМАУ-ын засгийн газрын төлөөлөгчдийг урьж Зөвлөлт-Хятадын хооронд яригдаж буй асуудлаар мэдээлэл хийж, зөвшилцөх нь зүйтэй гэж шийдсэн бололтой.

1945 оны 7 дугаар сарын шинэдээр ЗХУ-ын элчин сайд И. Иванов нь В.М. Молотовоос ирсэн цахилгаан утсыг Х. Чойбалсанд гардуулсан байна. Уг утсанд гүүнийг Москвад яаралтай хүрэлцэн ирэхийг урьсан байжээ. Чойбалсан 7 дугаар сарын 3 нд Зөвлөлтөөс тусгайлан ирүүлсэн “Дуглас” онгоцоор Улаанбаатараас гарч 4 ны өдрийн орой Москвад очиход нисэх онгоцны буудал дээр хүндэт харуул жагсааж В.М. Молотов болон албаны бусад хүмүүс угтаж авчээ. Ийнхүү өндөр хэмжээнд ёс төртэй угтан авсан нь ЗХУ-ын засгийн газар БНМАУ-ыг тусгаар тогтносон улс хэмээн үзэж бусад улс гүрнүүдийн нэгэн адил хүндэтгэн үздэгээ тэнд байлцсан Хятадын дипломат албаныхан болон сурвалжлагч нарт харуулах зорилготой байжээ.

Сталин нар 7 дугаар сарын 5 ны өдрийн орой Чойбалсанг Кремльд хүлээн авч уулзсан байна. Сталин юуны өмнө ДИУ-ын Үндэсний Гүйцэтгэх Юаны дарга Сун зывэнь Москвад ирээд байгааг мэдэгдээд: “Хятад улс танай Монгол улсыг одоо хүртэл хүлээн зөвшөөрөөгүй байсаар ирлээ. Энэ удаа манай зүгээс Монголыг тусгаар тогтносон бүрэн эрхэт улсын хувьд Хятадаар хүлээн зөвшөөрүүлэх тухай ярилцаж байгаа боловч бас ч дуртай биш байна. Миний бодоход энэ асуудлыг Хятадын төлөөлөгчид эцсийн бүлэгт зөвшөөрөх байх. Бидний хэлэлцээ үр дүнд хүрвэл ДИУ-аас танай Монголын тусгаар тогтнолыг зөвшөөрсөн тухай мэдэгдэл гаргана гэж бодож байна. Энэ талаар таны саналыг сонсох нь зүйтэй байна” гэсэн агуулгатай үг хэлжээ.¹⁰

Ярианы дараачын сэдэв нь Японы эсрэг дайнд БНМАУ-ын цэрэг ЗХУ-ын улаан армийн анги нэгтгэлүүдтэй хамт байлдах асуудал байв. Сталин Монголын армийн байлдах чадварыг товч асууж танилцаад: “Танайд байлдааны мэдлэг туршлага сайтай генерал Плиев гэдэг хүн манай цэргийг командалж очно. Чи тэр хүнийг штабын даргаар буюу өөрийн туслахаар ажиллууулах алин болохыг өөрөө мэд” гэжээ.

1945 оны 7 дугаар сарын 7 ны орой уламжлал ёсоор Кремльд Чойбалсанд зориулан зоог барив. Тэнд оролцсон МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга агсан Б. Ширэндэвийн товч тэмдэглэлд өгүүлснээр Сталин дараах агуулгатай үг хэлж хундага өргөсөн байна. “Монголд хоёр чиглэл байсан бөгөөд түүний нэг нь япончуудтай нөхөрлөхийг эрмэлзэж байсан, нөгөө нэг нь Зөвлөлт Холбоот Улстай нөхөрлөхийг эрмэлзэж байсан амуй. Би ЗХУ-тай нөхөрлөж сайн нөхрөө олсон Монголын удирдагч нарын төлөө хундага дэвшүүлэхийг хүсэж байна. Энэ нөхөд бол эндүүрсэнгүй. Энэ эв найрамдал нь зөв бөгөөд үнэн болохыг түүх биечлэн харуулав. Зөвлөлт-Монголын эв найрамдлыг тогтоосон монголын удирдагч нарын төлөө хундага дэвшүүлье. Тусгаар тогтносон Монгол улсын төлөө хундага дэвшүүлье. Монгол ардын нам, засаг болон нөхөр Чойбалсангийн удирдлагын дор өсөж хүмүүжсэн шинэ хүчнүүдийн төлөө хундага дэвшүүлье” гэжээ.

1945 оны 7 дугаар сарын 8 ны өглөө Х. Чойбалсанг Москвагийн нисэх онгоцны буудлаас явахад мөн л гурван төрлийн цэргийн хүндэт харуул жагсан хүндэтгэлтэйгээр үдэж явуулжээ. Монголын төлөөлөгчдийг буцаж ирсний дараа Үнэн

сонин 1945.7.13 ны дугаартаа “Тусгаар тогтносон Монгол ард улс мандтугай” гэсэн тэргүүн өгүүлэл нийтэлжээ. Түүнд “Бидний хүсэл бол өнө эрт цагаас малчин монголчуудын эзэмшсээр ирсэн Монгол нутагтаа бүрэн эрхтэй эзэн болж...ард түмнээ жаргуулан амьдруулахыг хүснэ. Манай энэ ариун зөв хүсэл бол бүтсэн ба хойшид хэлбэрэлтгүй бүтэх юм” гэжээ.

Сталин-Сун зывэнь нарын 3 дахь уулзалт 1945 оны 7 дугаар сарын 7 ны шөнө 11 цагаас 11 цаг 45 мин-ын хооронд болжээ. Энэ уулзалтан дээр Сун Чан Кайши-тай холбоо барьж БНМАУ-ын асуудлаархи Сталины байр суурийг дамжуулсан бөгөөд Чан дараах хариуг өгсөн гэжээ. Чан Кайши нь Ялтын гэрээнд тусгагдсан Гадаад Монголын одоогийн байгаа байдлыг /статус-кво/ хэвээр үлдээх гэсэн томъёололыг зөвшөөрч байна гэжээ. Өөрөөр хэлбэл Гадаад Монгол нь Хятадын эзэн мэдэх эрх /суверенитет/ доор харьяалагдах боловч үндсэндээ /де-факто/ биеэ даасан байдалтай байхыг хэвээр үлдээе гэсэн бяцхан дипломат аргыг Сун хэрэглэхийг оролдсон байна.

Гэтэл Сталин “статус-кво” гэдгийг БНМАУ-ын тусгаар байдал гэж тайлбарлан, энэ утгаар бид Зөвлөлтийн тал санаачилж Ялтын бага хурлын шийдвэрт тусгуулсан юм гэсэн хатуу байр суурьтай байлаа. Үүний хариуд Сун “Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөв. Цөөрсөн ямар ч Хятадын засгийн газар цааш оршин тогтнож чадахгүй. Үүнийг Хятадын олон нийтийн санал хэрхэвч хүлээн авч чадахгүй” гэж Сталинд дахин дахин учирласан байна. Түүнчлэн Сун бид Гадаад Монголд дээд зэргийн автономи эрх олгоход бэлэн байна. Энэ нь цэргийн болон гадаад харилцааг хамрах юм. Гадаад Монгол нь ЗХУ-тай хэрэгцээтэй гэж үзвэл цэргийн гэрээ байгуулж Зөвлөлтийн цэргийг нутагтаа оруулах эрхтэй байх юм гэж хүртэл ноцтой буулт хийсэн байна.

3 дахь уулзалтын төгсгөлд Сталин, Молотов нар 20 жилийн хугацаатай Зөвлөлт-Хятадын гэрээний төслийг Сунд гардуулжээ. Мөн

1. Найрамдал, холбоо тогтоох гэрээ
2. Дорнод Хятадын ба Өмнөд Манжуурын төмөр замын тухай
3. Порт-Артур ба Дайрэн боомтын тухай
4. Гадаад Монголын тусгаар тогтнолын тухай гэсэн 4 асуудлыг шийдэх, .. үүнтэй холбогдсон Зөвлөлтийн төслийг гардуулан өгсөн байна.

Ийнхүү БНМАУ-ын статус-квог 1924 оны Зөвлөлт-Хятадын гэрээнд заасан ёсоор тайлбарлах гэсэн Сун Зывэний оролдлого

бүтэлгүй болж, энэ асуудлаас болон бүх хэлэлцээ мухардалд орсон байна. Иймд Чан Кайши нь Сунтэй цуг Москвад очсон өөрийн хүү Зян Зинго-д хувийн цахилгаан илгээж түүнийг хувийн журмаар Сталинтай уулзаж Гадаад Монголын асуудлаар маш илэн далангүй санал солилцож хэлэлцээг мухардлаас гаргахыг даалгажээ.

Сталин Зян Зинго-гаас “Та нар яагаад Гадаад Монголын тусгаар тогтнолын асуудлаар тэс зөрөөд байгаа юм бэ?” гэж асуужээ. Үүнд Зян “Хятад нь өөрийн алдагдсан нутаг ” дэвсгэрийг эргүүлэн авахын төлөө 8 жилийн турш дайтаж ирсэн гэдгийг та ойлгох хэрэгтэй. Өнөөдөр Японыг хөөн явуулж чадаагүй, Зүүн Хойд Хятад болон Тайваныг эргүүлэн авч чадаагүй л байна. Энэ бүх алдагдсан нутаг бидний дайсны гарт хэвээр байна. Ийм томоохон нутгийг /Гадаад Монголыг хэлж байна/ өгнө гэдэг нь бидний хийж ирсэн Японыг эсэргүүцсэн дайны утга учир алдагдана гэсэн үг. Үүнийг манай ард түмэн уучлахгүй бөгөөд биднийг “улсын газар нутгаа наймаалагчид” /хятадаар чумай готу/ гэж нэрлэх болно. Иймд бид Гадаад Монголыг Орост өгөхийг яагаад ч зөвшөөрч чадахгүй” гэж хариулжээ.

Сталин “Таны ярьж байгааг би ойлгож байна. Гэвч өнөөдөр би та нарыг биш, та нар бидний тусламжыг хүсэж байгаа гэдгээ ойлгох хэрэгтэй. Хэрвээ та нарт хүч байгаад та нар өөрсдөө Японыг бутцохиж чадах байсан бол би та нарт иймэрхүү шаардлага тавихгүй байсан” гэжээ.

Үүнд Зян Зинго “Та нар яагаад заавал Гадаад Монголыг тусгаар тогнуулахыг хүсээд байгаа юм бэ. Хэдийгээр газар нутаг нь том боловч хүн ам цөөтэй, зам харилцаа үгүй шахам, онцгой үйлдвэрлэх зүйл ч үгүй биш үү” гэж асуусанд Сталин “Танд үнэнийг хэлье. Би зөвхөн цэрэг-стратегийн бодлогын үүднээс Монголыг хүсэж байгаа юм” гээд тэр газрын зураг дэлгэн үзүүлж “Хэрвээ ямар нэг гаднын цэрэг Монголоос ЗХУ-д дайрч Сибирийн төмөр замыг сэт цохих юм бол Орос дууслаа гэсэн үг” гэжээ.

Зян Зинго “Өнөөдөр цэргийн асуудлаар санаа зовох шаардлага байна гэж үү. Хэрвээ та нар Японы эсрэг дайнд оролцвол Япон нь дахин босож ирж чадахгүй бөгөөд түүнд Гадаад Монголыг эзлэн авч ЗХУ-ын эсрэг довтолх түшиц газар болгох тийм хүч үгүй болно. Японы аюулаас гадна Монголоос ЗХУ руу халдан довтолно гэж ярьвал Хятад л үлдэж байна. Гэтэл Хятад та нартай 25 жил, бүр 30 жилийн найрамдлын

гэрээ байгуулах гэж байна. Хятад танайд 30 жил халдаж чадахгүй. Халдахыг хүслээ ч хүч хүрэхгүй.” гэсэн байна.

Сталин “Та буруу ярьж байна. Япон нь бутцохигдсоны дараа Орост халдахын тулд Гадаад Монголыг дахин эзэлж авч чадахгүй гэж та ярьж байна. Нэг хэсэг хугацаанд тийм байх нь мэдээж. Гэхдээ Япон нь дахиад босоод ирнэ. Ямар ч хүчийг устгаж болно. Харин япон мэт үндэстний хүч чадлыг устгах арга байхгүй.”

Зян “Герман бууж өглөө. Та нар нэг хэсгийг нь эзэлж авсан. Герман дахин босож ирэх үү?”

Сталин “Тэгэлгүй яахав, босоод л ирнэ.”

Зян “Хэрвээ Япон дахиад босоод ирлээ ч гэсэн тийм түргэн чадахгүй биз ээ. Нэлээд хугацаанд та нар Японы эсрэг дайнд бэлтгэхгүй байж болох биш үү?”

Сталин “Эрт орой хэзээ боловч Япон нь заавал босож ирнэ. Хэрвээ Японыг АНУ-ын мэдэлд өгчих юм бол таван жилийн дараа л босоод ирнэ.”

Ярианы төгсгөлд Сталин бүр тэвчээр алдаж “Монголыг буцааж өгнө гэж санах ч хэрэггүй” гэсэн богинохон бөгөөд эцсийн хариултыг Зян Зинго-д өгчээ.¹¹ Зян энэ хариултыг өөрийн эцэг Чан Кайши-д тэр хэвээр дамжуулсан гэдэг нь ойлгомжтой.

Сталин-Сун нарын 4 дэх уулзалт 1945 оны 7 дугаар сарын 9 нд болсон байна. Уг уулзалтан дээр Сун Чан Кайши-гаас ирүүлсэн цахилгааныг бүтнээр нь Сталинд унших эгсэн байна. Чан Кайши Зөвлөлт-Хятадын хэлэлцээг мухардлаас гаргах зорилгоор хэрвээ Сталин доорхи 3 асуудлаар Хятадын саналыг хүлээж авбал Гадаад Монголын асуудлаар буулт хийхэд бэлэн байна гэсэн цахилгаан ирүүлсэн байна.

Жон Гарверын бичсэнээр 7 дугаар сарын 5 нд Чан Кайши Чунцинд Гоминьдан намын эрх баригчдын зөвлөлгөөнийг зарлан хуралдуулж Сталины шаардлагыг хүлээн авах эсэх асуудлыг хэлэлцжээ. Үүнд тэдний санал хоёр хуваагдаж нэг хэсэг нь Гадаад Монголын талаарх Сталины саналыг няцаах, нөгөө хэсэг нь Манжуур, Шинжаан зэрэг бусад асуудлаар Сталинаас баталгаа авсан нөхцөлд Гадаад Монголын асуудлаар буулт хийж болох юм гэсэн санал гаргажээ. Удтал маргасны эцэст уг зөвлөлгөөнөөс Гадаад Монголын талаарх Сталины шаардлагыг тодорхой болзолтойгоор хүлээн авах гэсэн шийдвэрт хүрчээ.¹²

Хятадын тал нэгд, Манжуурын талаарх Хятадын бүрэн эрх, түүний засаг захиргааны нэгдмэл байдлыг хадгалах, үүнд Порт-Артурыг хамтран эзэмших, Дайрэныг 20 жилийн хугацаатай нээлттэй боомт болгон зарлах, Дорнод Хятадын болон Өмнөд Манжуурын төмөр замыг хоёр орон хамтран ашиглаж ашгаа тэнцүү хувааж авах саналыг дэвшүүлжээ. Хоёрт, Шинжаанд 1944 онд бослого гарч Хятад болон Шинжааны хооронд худалдаа болон бусад харилцаа тасарсан. ЗХУ нь энэ асуудлаар Хятадтай хамтран ажиллаж Шинжаан дахь үймээнийг арилгах, Хятадтай худалдааны болон бусад харилцааг сэргээхэд туслахыг хүсчээ. Гуравт, Хятадын коммунистууд одоохондоо өөрийн захиргаа, өөрийн армитай тусдаа хүч болж байгаа тул хойшид Зөвлөлтийн сэтгэл санаа, эд материалын бүх л тусламжыг зөвхөн Хятадын төв засгийн газарт Чан Кайши-гийн засгийн газарт/ өгч байхыг хүссэн байна.

Чан Кайши эцэст нь цахилгаандаа 4 дэх асуудал болох Гадаад Монголын талаар дараах саналыг тавьжээ. Хэрвээ Зөвлөлтийн засгийн газар Хятадын дээрх 3 саналыг хүлээн авбал Хятадын засгийн газар нь Зөвлөлт-Хятадын харилцаанд үндсэн тээг болж буй Гадаад Монголын асуудлыг шийдэж Японыг ялсны дараа Гадаад Монголд тусгаар тогтнол олгохыг зөвшөөрч байна. Үүний тулд Гадаад Монголд энэ асуудлаар бүх нийтийн санал хураалт явуулах бөгөөд санал хураалтын дараа Хятадын засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг зөвшөөрч байгаагаа зарлана. Гадаад Монголын нутаг нь манай хятадын газрын зурагт зурагдсан тэр нутгийг хамарна. Зөвлөлт засгийн газар нь Хятадын засгийн газар хичнээн их хүчин чармайлт гаргаж байгааг ойлгоно гэж найдаж байна гэсэн цахилгаан байв.

Сун энэхүү санал хураалт явуулах саналыг Хятадын ард түмэнд яагаад Гадаад Монголыг тусгаар тогтноулах болов гэдгийг ойлгуулахад заавал шаардлагатай “хэлбэрийн асуудал” /face saving/ юм гэж тайлбарлажээ.

Сталин Чан Кайши-гийн эдгээр саналыг үндсэнд нь хүлээн авсан боловч Порт-Артур, Дайрэн зэргийг хамтран эзэмших хугацааг 20 жил бус дор хаяж 30 жил болгох хэрэгтэй гэх зэрэг хэд хэдэн сөрөг санал тавьжээ. Мөн Сталин Гадаад Монголыг Хятадын засгийн газар Японыг ялсны дараа биш одоо даруйхан хүлээн зөвшөөрөхийг шаардаж, харин энэхүү хүлээн

зөвшөөрсөн мэдэгдлийг Япон бууж өгсний дараа нийтэд ил болгож хэвлүүлэе гэсэн саналыг тавьсан байна.

Ийнхүү Сталин-Сун нарын 4 удаагийн уулзалтаар Зөвлөлт Хятадын хооронд найрамдал, холбооны гэрээ байгуулах, Зөвлөлтөөс Японы эсрэг дайнд оролцон Японыг буулгаж авсны дараа Гадаад Монгол /БНМАУ/, Манжуур, Шинжаан зэрэг газар нутгийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай хэлэлцэж үндсэн тохиролцоонд хүрсэн байна.¹³

1945 оны 7 дугаар сарын 11 нд болсон дараагийн уулзалт дээр Сталин-Сун нарын хооронд Гадаад Монголын талаар Хятадын засгийн газар болон Зөвлөлтийн засгийн газар хоёрын хооронд солилцох ноотын агуулгыг ярилцсан байна. Үүнд “БНМАУ-ыг одоогийн байгаа хилээр нь хүлээн зөвшөөрөх” гэсэн томъёоллыг Сталин гаргаж тавьсан байна.

Сталин-Сун нар 7 дугаар сарын 12 нд дахин нэг уулзсаны дараа Сталин, Молотов нар Берлинд болох холбоотон гүрний тэргүүн нарын уулзалтад оролцохоор явах болсон тул хэлэлцээг түр завсарлаж Сун Зывэнь Хятадад буцаж очин Чан Кайши-тай эцсийн байдлаар зөвлөлдөж ирэхээр харилцан тохиролцсон байна.

Хятадын төлөөлөгчид 8 дугаар сарын эхээр Москвад буцаж ирэн 8 дугаар сарын 7 нд тэд Сталин, Молотов нартай хэлэлцээгээ сэргээсэн байна. Өмнө нь Хятадын төлөөлөгчдийг тэргүүлж байсан Чан Кайши-гийн баз болох Сун Зывэнь ГЯЯ ны сайдын тушаалаас өөрийн хүсэлтээр огцорсон тул Ван Шизе ГЯЯ-ны шинэ сайдын хувьд хоёрдахь ээлжийн хэлэлцээг Хятадын талаас голчлон удирджээ. Сун Зывэнь ГЯЯ-ны сайдаас гэнэт огцрох болсныг тэрбээр Гомиьнданы засгийн газрыг төлөөлж Гадаад Монгол зэрэг Хятадад нэн эмзэг асуудлаар “гутамшигтай” гэрээнд гарын үсэг зурахыг хүсээгүйтэй холбон тайлбарладаг.

Сталин 8 дугаар сарын 7 нд болсон уулзалт дээр Гадаад Монгол, Порт-Артур, Дайрэн, Дорнод Хятадын төмөр зам зэрэг асуудлаар Зөвлөлтийн тал Хятадад хатуу нөхцөл болзол тавих болсон шалтгааныг дахин илэн далангүй тайлбарласан байна. Сталинаас: “Япон нь бууж өгөх боловч дахин сэргээд ирнэ. Үүнийг бодолцохгүй байж огт болохгүй. Бидэнд өөрсдийн цэргийн болон худалдааны боомтыг бий болгоход дор хаяж 30 жил хэрэгтэй гэдгийг би хэлсэн. Энэ 30 жилд юу болох вэ? Япон нь дахин босоод ирэх магадлал ихтэй. Алс Дорнод дахь манай Владивосток, Советское, Петропавловск

боомтууд нь бүгд асар их хуучирчээ. Мөн Алс Дорнодод нэмж төмөр зам барихад хугацаа хэрэгтэй. Бид боомтуудаа шинэчлэн тоноглож, шинэ төмөр замтай болоход дор хаяж 30 жил хэрэгтэй. Иймээс манай хоёр орны эрх ашгийн тусын тулд бид Өмнө зүгт боомттой байхыг маш ихэд сонирхож байгаа юм. 30 жилийн дараа бидэнд Хятадад боомттой байх, төмөр замтай байх шаардлага үгүй болно. Хэрвээ Японы зүгээс ийм аюул байгаагүй бол бид та нараас нөхцөл болзол шаардах хэрэггүй байсан юм” гэж тайлбарлажээ.

8 дугаар сарын 10 нд болсон Сталин-Ван нарын уулзалт дээр Гадаад Монголын /БНМАУ-ын хилийн шугамын асуудал босож ирсэн байна. Хятадын ГЯЯ-ны сайд Ван Гадаад Монголыг Хятадын зүгээс хүлээн зөвшөөрөхөөс өмнө Гадаад Монголын хилийн шугамыг тодруулж тодорхой болгох шаардлага тавьжээ. Тэрбээр үүний шалтгааныг “Гадаад Монголын хилийн шугам нь мөргөлдөөн гарах шалтаг болж байсан. Бид Хятадын бүх л их дээд сургуульд хэрэглэдэг газрын зургийг авчирсан юм. Энэ зургийг итгэж болно. Бид Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрнө гэдгээ хэлсэн. Гэвч бид чухам ямар газар нутгийн хүрээнд Гадаад Монголыг хүлээн зөвшөөрөх гэж байгаагаа ард түмэндээ хэлэх ёстой. Бид энэ асуудлыг ерөнхийд нь тохиролцмоор байна. Бидэнд та нарыг хуурах юм уу, эсвэл илүү ашиг олж авах бодол байхгүй. Манай газрын зураг дээрх Гадаад Монголын хилийн шугам бидэнд буй Зөвлөлтийн зурагтай таарч тохирч байгаа юм” гэж тайлбарласан байна.

Сталин үүний хариуд “БНМАУ-ын хилийн шугамын талаар 26 жилийн турш Хятадтай ямар нэг маргаан гаралгүй явж ирсэн. Манай газрын зураг хийдэг хүмүүс Монголд очиж Хятад-Монголын хилийн шугамын зургийг үйлдсэн юм. Энэ нь Монголын баруун болон өмнөд хилийг хамарч байгаа юм. Зүүн хил дээр япончуудтай маргаан мөргөлдөөн гарч байсан. Дараа нь бид тэдэнтэй хэлэлцэн тохирсон. Хэрвээ одоо бид хилийн шугамыг дахин шалгаж тогтоох юм бол их хугацаа шаардана, нэг хэсэг газрыг өгч авалцах ч хэрэг гарч мэднэ” гэжээ.

Ван үүнд ноднин /1944 онд/ Шинжаан ба Гадаад Монголын хооронд хилийн будлиан гарч байсныг сануулжээ. Сталин энэ будлиан нь хилийн шугамтай хамаагүй. Энэ нь хилийн шугамыг даван орж ирсэн казахуудын удирдагч Оспантай холбоотой. Монголчууд түүнийг буцааж өгөхийг

хүсэхгүй байсан. Будлиан хилийн шугамтай холбоогүй гэж маргажээ.¹⁴

Гадаад монголын хилийн шугамыг тодруулж авах гэж Гоминьданы засгийн газар зүтгээд байсны учир юу вэ гэсэн асуулт гарч байна. Энэ тухай 1993 онд Бээжинд хэвлэгдсэн “Гадаад Монголын тусгаар тогнолын нууц учир” номыг зохиогчид Гоминьданы засгийн газар нь Гадаад монголын тусгаар тогтнолыг зөвшөөрөхөөс өмнө Алтайн хязгаарын маргааныг шийдвэрлэх, Шинжаан болон Гадаад Монголын хилийн шугамыг тогтоохыг зорьж байсан гэж бичжээ. 1911 оноос өмнөх Алтайн хязгаар бол Гадаад Монголын нэг хэсэг байсан. Гэвч БНМАУ байгуулагдах үед Алтай нь Шинжаанд харьяалагджээ. 1940 оны Зөвлөлтийн газрын зурагт Алтайн хязгаарын бараг 215,000 хав, дөр. км газрыг БНМАУ-д оруулан зурсан гэж уг номыг зохиогчид бичжээ. Иймд Чунцины засгийн газар хэрвээ тусгай гэрээ байгуулж Алтай нь Хятад улсад харьяалагдана гэдгийг тодорхойлохгүй бол Гадаад Монголын тусгаар тогтнолыг “одоогийн байгаа хилээр” зөвшөөрөх нь баруун Алтайг таслан өгсөн хэрэг болно гэж үзэж байсан хэмээн тайлбарлажээ.¹⁵

Сталин ийнхүү Чан Кайши-гийн засгийн газар Алтайн Хязгаарт санаа зовж байсныг ойлгосон эсэх нь өнөөдөр тодорхой биш. Харин тэрбээр Хятадын тал Гадаад Монголын тусгаар тогтнолыг зөвшөөрөхөөс өмнө хилийн шугамыг тодруулая гэсэн шаардлага тавьсныг Хятадын тал авсан амлалтаасаа няцаж Гадаад Монголын тусгаар тогтнолыг зөвшөөрөхгүй байх шалтаг эрж цаг хожихыг оролдож байна гэж хардсан бололтой.

Иймд Сталин энэхүү 8 дугаар сарын 10-ны уулзалт дээр Ван нарын хятадын төлөөлөгчдөд “Бид үүнийг зөвшөөрөхгүй. Та нар бүх зүйлийг хойшлуулахыг хүсэж байна. Та нар амлалтаа буцахыг оролдож байна. Хэрвээ та нар шалтаг эрж байгаа бол шууд л тэрийгээ хэлчих” гэж дайрсан байна.

Сталин үүн дээр нэмж “Монголчууд Гадаад, дотоод Монголыг нэгтгэхийг маш их хүсэж байгаа юм. Иймд хилийн шугамын асуудлыг босгож тавихгүй байх нь зүйтэй. Тэднийг энэ мөрөөдлийг нь орхиулахын тулд Гадаад Монголыг даруйхан хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байна. Хэрвээ тэд Дотоод Монголыг нэгтгэхийг хүсвэл дайн болно гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Орос өөрийн зүгээс тэднийг хил хязгаараа өргөтгөхөд туслалцаа үзүүлэхгүй” гэж мэдэгдсэн байна. Өөрөөр хэлбэл

Сталин та нар даруйхан Гадаад Монголыг хүлээн зөвшөөрөхгүй бол Дотоод Монголын асуудал босож ирэн, Дотоод Монгол ч Хятадаас тусгаарлах асуудал тавигдах болно гэж нэг ёсны шахалт үзүүлжээ.

Үүний дараа Хятадын төлөөлөгчид Чан Кайши-тай дахин дахин цахилгаан солилцож зөвлөлдсөний эцэст Гадаад Монголын хилийн шугамыг эхлээд тогтоох шаардлагаасаа татгалзаж, Гадаад Монголыг одоогийн байгаа хилийн шугамаар нь хүлээн зөвшөөрье гэсэн саналд хүрчээ. Ийнхүү 8 дугаар сарын 13 ны өдрийн уулзалт дээр Хятадын төлөөлөгчид Гоминьданы засгийн газар Сталины саналыг хүлээн авч, Гадаад Монголыг одоогийн байгаа хилээр нь хүлээн зөвшөөрөхөөр шийдсэнээ мэдэгдсэн байна.

Сталин БНМАУ-ын удирдагчид Дотоод Монголыг нэгтгэж нэгэн нэгдмэл улс байгуулах хүсэлтэйг сайн мэдэж байсан бололтой. Гэвч Сталины 8 дугаар сарын 10 нд Хятадын төлөөлөгчдөд хийсэн мэдэгдлээс үзвэл тэрээр энэ хүсэлтийг дэмжих сонирхол байгаагүй бөгөөд харин үүнийг нэг шалтаг болгон Хятадаар БНМАУ-ыг л аль болох түргэхэн хүлээн зөвшөөрүүлэх зорилготой байсан гэж ойлгогдож байна. Гэтэл БНМАУ-ын удирдагчид 8 дугаар сарын 10 нд Японд дайн зарлахын хамт “Монгол овогтон нэгэн гэр улс болох” хатуу эрмэлзэлтэйгээ зарлан мэдэгдсэн билээ. Чойбалсан 8 дугаар сарын 10 нд Монголын ард түмэнд хандаж радиогаар хэлсэн үгэндээ “...Бид баатар улаан цэрэг болон нэгдсэн улс үндэстний хамт Японы фашистуудыг бүрмөсөн устгаж Японы түрэмгийлэн эзлэгч нарыг бутцохисны эцэст бүх монголчуудыг эрх чөлөөтэй, тусгаар тогтносон, бүрэн эрхэт нэгэн ах дүү улс гэр болгон нэгдүүлэх явдлыг хангах болно” гэж хэлж байжээ.

ЗХУ ба ДИУ-ын хооронд 1945 оны 8 дугаар сарын 14 нд БНМАУ-ын тусгаар тогтнол хийгээд газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх тухай ноот бичиг солилцов. Хятадын талын ноотод “Японыг дарсны дараа Монголын ард түмний нийтийн хүсэл, энэ эрмэлзэлээ батлах ахул Дундад улсын засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг одоогийн байгаа хилээр нь зөвшөөрч байна” гэсэн мэдэгдэл хийжээ.¹⁶

1945 оны 10 дугаар сарын 20 нд Монгол даяар улс орон цаашид хэрхэн орших асуудлаар санал асуулга явуулж, монголын ард түмэн тусгаар тогтнолоо илэрхийлсэн хэвээр хадгалан хөгжих хүслээ 100 хувь илэрхийлсэн юм. Санал асуулгын дүнг ЗХУ, Хятад улсад албан ёсоор мэдэгдсэний

дараа 1946 оны 1 дүгээр сарын 6 нд Чан Кайши-гийн засгийн газар БНМАУ-ыг хүлээн зөвшөөрч, мөн оны 2 дугаар сарын 10 нд БНМАУ, Дундад Иргэн улсын хооронд дипломат харилцаа тогтоох болон дипломат төлөөлөгч харилцан суулгах тухай ноот бичгийг солилцжээ.

1. Foreign Relations of the United States. Diplomatic Papers. The Conferences at Cairo and Teheran. 1943. -Wash., 1961, pp. 325-326, 367.
2. John W. Garver, Chinese-Soviet Relations, 1937-1945: The Diplomacy of Chinese Nationalism, New York, Oxford, 1988. p. 197-198.
3. СССР на международных конференциях периода Великой Отечественной войны 1941-1945 гг. Крымская конференция руководителей трех союзных держав -СССР, США и Великобритании. 4-11 февраля 1945 г.: Сборник документов.- М., 1984. – Т. 4, с. 130.
4. Мөн тэнд.
5. John W. Garver, p. 209.
6. John W. Garver, p. 212.
7. Уг хэлэлцээний протоколын англи хэл дээрх орчуулга АНУ-ын Станфордын Их Сургуулийн Гуверын институтын архивт хадгалагдаж байна. Диссертацид энэхүү эхийг ашигласан болно.
8. 30th June- 14 August 1945, "Notes taken at Sino-Soviet Conference", Victor Hoo papers, Hoover Institution Archives, Stanford University.
9. American Diplomatic Documents, vol. VII. Washington, 1945, p. 202.
10. Л. Бат-Очир, Чойбалсан, УБ., 1996, 173-174 -р тал.
11. Цит. по Ю. Гарушянц, Борьба за признание независимости Монголии, - "Проблемы Дальнего Востока", № 2, 1997, с. 118-119.
12. John W. Garver; p. 217-218.
13. Victor Hoo papers, Hoover Institution Archives, Stanford University.
14. Ваймэнгү дули нэйму, Бэйзин, 1993.
15. Gerard M. Friters, Outer Mongolia and its International Position, Baltimore, The Johns Hopkins Press, 1949, p. 210.